



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2014 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 343

Улаанбаатар хот

Хорооны 2013 оны 249 дүгээр тогтоолоор батлагдсан
журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 7 дугаар сарын 17-ны өдрийн 249 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгагчийн төлбөрийн чадварыг тооцох журам”-ын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт доор дурьдсан агуулгатай 3.2.1¹ дэх заалт нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1¹ дэх заалтууд:

| Хөрөнгийн ангилал | Хөрөнгө байршуулах дээд хувь | Нэгжид ногдох хөрөнгийн дээд хувь | Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь |
|---|------------------------------|-----------------------------------|--------------------------------|
| Баганын дүн | 1 | 2 | 3 |
| 3.2.1 ¹ Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээл | 30%* | 30%* | 50% |

*Хувь нийлүүлсэн хөрөнгө буюу дүрмийн сангийн хөрөнгөөс тооцно.

2/ Мөн журмын нэгдүгээр хавсралт “МАЯГТ-1”-д “.....” ХК-ийн 20... оны ... дүгээр улирлын зөвшөөрөгдөхгүй хөрөнгийг тооцох аргачлал”-д доор дурьдсан агуулгатай дараах 1¹ дэх мөрийг нэмсүгэй:

| Хөрөнгийн ангилал | Хөрөнгийн байршуулах дээд хувь | Нийт хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн | Нэгжид ногдох хөрөнгө байршуулах дээд хувь | Нэгжид ногдох тухайн хөрөнгийн зөвшөөрөгдөхгүй дүн | Зөвшөөрөгдөхгүй хөрөнгийн хувь | Зөвшөөрөгдөх хөрөнгийг бууруулах дүн | Нийт зөвшөөрөгдөхгүй дүн |
|---|--------------------------------|------------------------------------|--|--|--------------------------------|--------------------------------------|--------------------------|
| Баганын дүн | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7=2+4+6 |
| 1 ¹ Даатгалын үндсэн үйл ажиллагаанд зориулан авсан зээл | 30%* | | 30%* | | 50% | | |

* Хувь нийлүүлсэн хөрөнгө буюу дүрмийн сангийн хөрөнгөөс тооцно.

2. Дээрх журамд нэмэлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН